БАТЛАВ.
БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ЭНХ-АМАР

УЛААНБААТАР ХОТ
БИОКОМБИНАТ ТӨХХК
0523050157
В202485 ☎ СБТ22211

НҮҮРСНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны нэр төрөл, нэр: Түүхий нүүрс (технологийн)
Биокомбинат ТӨХХК-ийн Дулааны станцын зуухнууд (KE-10/14, KE-6,5/14, SZL-4/1.25AII)-ын технологийн горим, нүүрсний стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

KE, SZL зуухны технологийн хүрэн нүүрсний техникийн үзүүлэлт:

№	Үзүүлэлтийн нэр	Тэмдэглэгээ	Нэгж	Шинж чанар
1	Дулаан гаргах чадвар	$Q^{н}_{р}$	ккал/кг	3360-3800
2	Чийглэг	$W^{р}$	хувь	15-32
3	Үнслэг	$A^{р}$	хувь	18-с ихгүй
4	Хүхэрлэг	$S^{р}$	хувь	0.35
5	Дэгдэмхий бодис	$V^{г}$	хувь	40.0-с ихгүй
6	Бутармагийн хэмжээ	X	мм	0-300

Стандарт шаардлага: Нийлүүлэх нүүрс нь Баганууурын уурхайн MNS3818:2001 стандарт буюу түүнтэй дүйцэхүйц техникийн үзүүлэлттэй байна.
Барааны тоо хэмжээ: Түүхий нүүрс (технологийн)-1258 тонн
Нүүрс нийлүүлэх эцсийн хугацаа: 2025 оны 12-р сарын 25-ны өдөр байна.

Ерөнхий шаардлага:
1. Нийлүүлэх нүүрсэн дэх 10-20 мм-ээс дээш хэмжээний шавар, чулуулгын хольц жингийн 3 хувиас хэтрэхгүй байна. 10-20 мм-ээс дээш шавар, чулуулгын хольц дээрхи заалтаас хэтэрсэн бол хүлээн авахгүй.
2. Тендерт нийлүүлэх нүүрсний техникийн шаардлагыг хангаж буй тухай Үндэсний итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг тендерт хавсаргаж ирүүлнэ.
3. Нүүрс нийлүүлэгч нь Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас өгсөн цахим зөвшөөрлийн дагуу дамжин өнгөрөх постуудаар бүртгүүлэн өөрийн зардлаар Биокомбинат ТӨХХК-ийн Дулааны станцын нүүрсний талбайд хүргэж, захиалагч (Биокомбинат)-ийн баталгаат пүүгээр жинлэж хүлээлгэн өгнө.
4. Нүүрсийг уурхайгаас ангилан ачих, автомашинаар тээвэрлэх, эцсийн цэгт буулгах-хүлээлгэн өгөх, тээврийн хэрэгсэл бүрт GPS суурилуулах, дамжин өнгөрүүлж, шалган нэвтрүүлэх зардал, бусад татвар, хураамж г.м бүх зардал тендерийн нийт үнэд багтсан байна.
5. Нүүрс нийлүүлэх эцсийн хугацаа нь 2025 оны 12-р сарын 25-ны өдөр байна.

6. Нүүрсийг эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай нүүрсний суурь үнэ, төмөр зам, авто тээвэр, даатгал, НӨАТ болон холбогдох бусад албан татвар, хураамжыг тооцож гаргасан нийт үнийн тооцооллыг хавсарган ирүүлнэ.
7. Нийлүүлэгч нь Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны цахим сайтад тээврийн хэрэгслийн мэдээллийг бүртгүүлж, нүүрс тээвэрлэх зөвшөөрлөө авна.
8. Нүүрс зөөх автомашин нь өөрөө буулгагч автомашин байх ба нүүрсний тоос агаарт дэгдэхээс сэргийлсэн зориулалтын хучлага, бүтээлэгтэй байна.
9. Нүүрс тээвэрлэх автомашин бүрт GPS төхөөрөмж суулгасан байна.
10. Нүүрсийг нийлүүлэгч нь ажлын өдрүүдэд 09.00-21.00 цагт нүүрсээ хүлээлгэн өгнө.
11. Нүүрсийг амралт, баяр, ёслолын өдрүүдэд тээвэрлэхээр бол Нийслэлийн Захирагчийн ажлын алба болон Захиалагчид заавал урьдчилан мэдэгдэнэ.

БОЛОВСРУУЛСАН:
БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН ИНЖЕНЕР,
ТЕХНИКИЙН АЛБАНЫ ДАРГА Ц.БУЯНТОГТОХ